



ᠤᠯᠤᠰᠤᠨ ᠲᠡᠷᠭᠦᠭᠦᠨ ᠢᠷᠬᠤᠨ ᠰᠤᠮᠤ
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ ᠲᠠᠮᠭᠢᠨ ᠭᠠᠵᠠᠷ

ОРХОН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТАЙЛАН

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ОРХОН СУМ

2

**ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 2025 ОНЫ
ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН**

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ

2025.12.22

Орхон

НЭГ.ХЯНАЛТ -ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮНЭЛГЭЭ ХИЙХ ҮНДЭСЛЭЛ

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 43 дугаар тогтоолоор баталсан “Хяналт-шинжилгээ хийх журам” “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам”, Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны “Аргачлал, загвар батлах тухай” 100 дугаар тушаалыг тус тус үндэслэв.

ХОЁР.ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ЗОРИЛГО

Засаг даргын Тамгын газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 2025 оны жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүнг нэмэгдүүлэх, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулан холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, шаардлагатай дүгнэлт, санал, зөвлөмж боловсруулахад оршино.

ГУРАВ.ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ

Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 43 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам”-ын 2.4-т заасан аргачлалын дагуу дүгнэж, 2.5.1, 2.5.2, 2.5.3-т заасан ангилалд шилжүүлэн тооцож, тус бодлогын баримт бичгийн үр дүнг 6.5-д зааснаар дүгнэсэн.

- “Бүрэн хангалттай” төлөвлөгөөний хэрэгжилт 85 түүнээс дээш хувь (арга хэмжээ оновчтой тодорхойлогдсон, зорилтод түвшиндээ хүрсэн, удирдлага зохион байгуулалт сайн, үр дүнг гарсан, эсхүл шалгуур үзүүлэлт, зорилтод түвшиндээ бүрэн хүрээгүй, үр дүн гарч эхэлсэн)
- “Хангалттай” төлөвлөгөөний хэрэгжилт 70-85 хүртэл хувь бол (шалгуур үзүүлэлт, зорилтод түвшиндээ бүрэн хүрээгүй, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулах)
- “Хангалтгүй” төлөвлөгөөний хэрэгжилт 70 хүртэл хувь бол (удирдлага, зохион байгуулалт хангалтгүй, төсөв хөрөнгийг үр дүнтэй зарцуулж чадаагүй нь баримтаар нотлогдсон)

ДӨРӨВ.ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ҮР ДҮН

Тамгын газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний жилийн эцсийн хэрэгжилтийг хариуцсан нэгж, алба, албан тушаалтнаас цаасан суурьтайгаар хүлээн авч, холбогдох хууль тогтоомжийг үндэслэн хяналт-шинжилгээ хийж ажилласан болно.

Засаг даргын Тамгын газрын 2025 оны төлөвлөгөөг хэрэгжүүлэхээр 8 чиглэлийн хүрээнд 20 зорилт, 50 арга хэмжээ хэрэгжилтэд хэрэгжүүлэн биелэлтийг тайлагнан ажилласан байна.

Хяналт-шинжилгээ, үнэлгээг Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 43 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам”-ын 2.4-т заасан аргачлалын дагуу дүгнэхэд нийт 20 зорилт 50 арга хэмжээнээс 49 нь 85-100 хувь буюу 99 хувийн хэрэгжилттэй,

журамд зааснаар “Бүрэн хангалттай” буюу хэрэгжилтийн дундаж нь 99 хувьтай байна.

ЗДТГ-ын Чанарын менежментийн тогтолцооны ISO 9001:2015 стандартын хүрээнд баримт бичгийг байнга сайжруулах, баримтжуулалтын үйл явцыг хэрэгжүүлэх чиглэлээр төлөвлөсөн 10 арга хэмжээнээс 9 нь бүрэн хэрэгжиж, 1 арга хэмжээ хэрэгжилтийн шатанд байна.

Үүний үр дүнд хэрэгжилтийн түвшин 90 хувьтай үнэлэгдэж, журамд зааснаар “бүрэн хангалттай” гэж дүгнэгдсэн болно.

Хүснэгтээр харуулбал

№	Чиглэл Агуулга	Зорилтын тоо	Арга хэмжээний тоо	Хэрэгжилтийн хувь				Хувь
				0-69	70-84	85-100	ХБ	
1.	Нэг. Санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх	4	11			11		100
2.	Хоёр. Гамшгаас хамгаалах чадавхыг нэмэгдүүлэх	1	5			5		100
3.	Гурав. Гэмт хэргээс урьдчилан сэргийлж, иргэдийн аюулгүй, амар тайван байдлыг хангана	4	4			4		100
4.	Дөрөв. Хөгжлийн бодлого, чиг үүргийн шинжилгээнд тулгуурласан захиргааны оновчтой, уян хатан, үр дүнтэй, үр ашигтай бүтэц тогтсон байна.	3	4			4		100
5.	Тав. ЗДТГ-ын ЧМТ ISO9001:2015 стандартын баримт бичигт байнгын сайжруулалт хийх, баримтжуулалтын үйл явцыг хэрэгжүүлэх	3	10	1		9		90
6.	Зургаа. Төрийн албан хаагчдыг цаг хугацаа, орон зайнаас үл хамааран сурч хөгжих орчныг бүрдүүлж, мэдлэг, чадварыг дээшлүүлэн, тогтвор суурьшилтай ажиллуулах, нийгмийн баталгаа хангах, хариуцлага сахилгыг өндөржүүлэх	2	7			7		100
7.	Долоо. Хяналт шалгалтыг хэрэгжүүлж эрсдлээс сэргийлэх	2	6			6		100
8.	Найм. Мэдээ, мэдээлэл бэлтгэх ЗДТГ-ын үйл ажиллагааг сурталчлах	1	3			3		100
Нийт		20	50	1		49		99

ДӨРӨВ.ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭНИЙ ДҮГНЭЛТ

Нийт 8 чиглэлийн хүрээнд 20 зорилт, 50 ажил, арга хэмжээнээс оновчтой тодорхойлогдсон, зорилтот түвшиндээ хүрсэн, удирдлага зохион байгуулалт сайн, үр дүн гарсан, эсхүл шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй, үр дүн гарч эхэлсэн 49 ажил, арга хэмжээ, зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулах 1 ажил, арга хэмжээ байна.

Үүнд:

Гүцэтгэлийн төлөвлөгөөний 12.5

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 07 дугаар тогтоолын хэрэгжилт хангагдсан байна.	2025 оноос хэрэгжиж эхэлж байгаа.	5.Төрийн байгууллагын шийдвэр, албан бичгийг энэ тогтоолын 4-т заасан дүрэм, журам, заавар, стандартын дагуу хос бичгээр хөтлөх ажлыг турших; Төрийн байгууллагын гадна болон өрөө тасаггааны хаяг, албан хаагчдын нэрийн хуудсыг монгол бичгээр үйлдэж, хэвшүүлэх.	Сумын Засаг дарга болон ЗДТГ-ын даргын 2025 онд гаргасан 256 албан бичиг хос бичгээр хөтлөгдөж байна. ЗДТГ-ын гадна хаягийг монгол бичиг болгон хаягжуулж 1.2 сая төгрөг зарцууллаа.	60
--	-----------------------------------	---	--	----

ТАВ.ЦААШИД АНХААРАХ АСУУДАЛ

Гүйцэтгэлийн тайлангийн хэрэгжилтэд анхаарч, төлөвлөгөөт ажлуудаа тогтоосон хугацаанд хэрэгжүүлж, хариуцсан албан хаагчийг үүрэгжүүлж, хяналт тавьж ажиллах

ТАНИЛЦСАН:

ЗДТГ-ЫН ДАРГА *[Signature]* **С.ДЭЛГЭРЖАРГАЛ**

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ

БАГИЙН АХЛАГЧ *[Signature]* **А.БОЛОРЧИМЭГ**

ГИШҮҮН *[Signature]* **Ц.ЦЭРЭНПИЛ**

[Signature] **Д.МИШЭЭЛТ**

111 0026 9022732

“Байгууллагын үйл ажиллагаа,
үр дүнг энэлж дүгнэх журм”-ын
2 дугаар хавсралт

ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ

НЭГ.ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИОЛГО, ҮНДЭСЛЭЛ, АРГА ЗҮЙ

Хяналт-шинжилгээг хийхдээ Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 43 дугаар тогтоол, тогтоолын 3 дугаар хавсралт “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам”-ын 3.7-т заасан аргачлалаар хууль тогтоомжийг ерөнхий ангиллаар нэгтгэн дүгнэв.

Хууль, тогтоомжийн тоо их, олон салбарыг хамарсан тул хэрэгжилтийн ерөнхий дүр зургийг харуулах зорилгоор ерөнхий ангиллаар нэгтгэсэн болно.

Хүснэгтээр харуулбал

№	Шийдвэр	Нийт	Засгийн газрын тогтоол	Төрийн удирдлага, захиргааны тухай хуулиуд	Төсөв, санхүү, худалдан авалт	Газар, барилга, хот байгуулалт	Байгаль орчин, эрүүл мэнд	Нийгмийн хамгаалал, хүний эрх	Хяналт, алига, ашиг сохирхол	Төрийн алба, хүний нөөц	Засгийн газрын албан даалгавар	Сумын ИТХурлын тогтоол
1	Хяналтад авсан шийдвэрийн тоо	45	2	4	5	4	4	4	3	4	2	13
2	Хяналтад авсан нийт заалтын тоо	259	12	10	139	6	16	8	10	54	4	-
3	Үүнээс											
	Хэрэгжсэн	272	12	10	139	6	16	8	10	54	4	13
	Хэрэгжээгүй	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
	Хугацаа болоогүй	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Хэрэгжилтийн ерөнхий дүн		100	100	100	100	100	100	100	100	100	100	100

Хяналт-шинжилгээ, үнэлгээнд хамрагдсан хууль, тогтоомж, Засгийн газрын тогтоол, албан даалгавар болон бусад шийдвэрийн хэрэгжилтийг үнэлэхэд нийт хэрэгжилтийн түвшин 100 хувьтай гарсан нь хэрэгжилт ерөнхийдөө хангалттай, бодит үр дүнтэй байгааг харуулж байна.

Хяналтад авсан шийдвэр, заалтын дийлэнх нь хугацаандаа хэрэгжиж, холбогдох арга хэмжээ, зохион байгуулалтын ажил зохих түвшинд хийгдсэн байна.

Цаашид хэрэгжилтийн үр дүнг хадгалах, чанарыг дээшлүүлэх хүрээнд хууль, тогтоомжийн хэрэгжилтэд тогтмол хяналт тавих, хугацаа шаардах арга хэмжээг урьдчилан төлөвлөж, гүйцэтгэлийг шат дараатайгаар хангах, тайлагнал, мэдээллийн уялдаа холбоог сайжруулах шаардлагатай гэж дүгнэв.

ЗӨВЛӨМЖ

- ✓ Хууль, тогтоомжийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээг тогтмол явуулах, хэрэгжилтийн явцыг улирал, хагас жилээр дүгнэн тайлагнах, гарсан зөрчил, дутагдлыг тухай бүрт нь арилгах арга хэмжээг авч ажиллах.
- ✓ Хэрэгжилтийн тайлагнал, мэдээллийн уялдаа холбоог сайжруулах, холбогдох баримт бичиг, нотлох материалын бүрдүүлэлтийг стандартын дагуу хөтлөх, мэдээллийг нэгдсэн сангаар дамжуулан хадгалах.

- ✓ Албан хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, хууль, тогтоомжийн хэрэгжилт, хяналт-шинжилгээ, үнэлгээний чиглэлээр сургалт, мэдээллийг тогтмол зохион байгуулах
- ✓ Хариуцсан албан хаагчийг үүрэгжүүлж, хяналт тавьж ажиллах

ТАНИЛЦСАН:

ЗДТГ-ЫН ДАРГА

С.ДЭЛГЭРЖАРГАЛ

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ


БАГИЙН АХЛАГЧ

А.БОЛОРЧИМЭГ

ГИШҮҮН

Ц.ЦЭРЭНПИЛ

Д.МИШЭЭЛТ



“Байгууллагын үйл ажиллагаа,
үр дүнг үнэлж дүгнэх журам”-ын
4 дүгээр хавсралт

**ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ОРХОН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ЕРӨНХИЙ ДҮН**

Үзүүлэлт		Хувь	Жин
1	2	3	4
Бодлогын үр дүн	“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хэрэгжилтийн явц, үр дүн	100	0.3
	Аймаг сумын хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт	93.3	
Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн дүн	Байгууллагын тухайн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэл	99.9	0.4
	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт	100	
Байгууллагын чадамжийн үнэлгээ	Хүний нөөцийн үйл ажиллагаан дахь чадахуйн зарчмын хэрэгжилт	100	0.2
	Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилт	100	
	Ёс зүй, сахилга хариуцлагын үнэлгээ	100	
	Санхүүгийн аудитын дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилт	100	
	Хяналт-шинжилгээ зөвлөмжийн хэрэгжилт	100	
Хөдлөнгийн болон оролцогч талуудын үнэлгээ	Төрийн албан хаагчдын сэтгэл ханамжийн судалгааны дүн	91.6	0.1
	Ил тод байдлын болон шилэн дансны үнэлгээ	99.1	
	Байгууллагын шударга байдлын үнэлгээ	-	
	Хэрэгчийн үнэлгээний дүн	87.9	
Нэмэлт оноо	Байгууллагын үйл ажиллагааны дүн		
Ерөнхий дүн		98.2	1.0

ТАНИЛЦААН:

ЗДТГ-ЫН ДАРГА  С. ДЭЛГЭРЖАРГАЛ

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ

БАГИЙН АХЛАГЧ  А. БОЛОРЧИМЭГ

ГИШҮҮН  Ц. ЦЭРЭНПИЛ

Д. МИШЭЭЛТ

11026 ы. 9022732